

ЧИНГИС ХААНЫГ МОНГОЛЫН НИЙГМИЙН ӨНЦГӨӨР ХАРАХ ХЭРЭГТЭЙ

*Ж. Заанхүү**

Чингис хааныг үнэлэх үгүйсгэх хандлага

Чингис хааны дэлхий дахинд гүйцэтгэсэн түүхэн үүргийн талаар гадаад дотоодын олон арван эрдэмтэд, судлаачид ихээхэн хүч чармайлт тавин хөдөлмөрлөж, өөрсдийн үзэл бодол, байр суурийг гарган тавьж, үнэлэлт дүгнэлт хийж иржээ.

Гэхдээ XIII зууны үед явуулж байсан Чингис хааны үйл ажиллагааг дэлхий дахиныг засан тохинуулахад чиглэсэн хэмээн авч үзэж, орчин үеийн даяарчлалын үйл явцтай холбон тайлбарлах, түүний түүхэн байр суурийг үнэн зөв, бодитой тавих явдал эрдэмтэд судлаачдын анхааралд төдий л өртөлгүй явж иржээ. Энд тухайн үеийн түүхийн нөхцөл байдал, түүхийн баримт эх сурвалжийг анхааралтай судлах, нүүдэлчдийн амьдралын онцлог, уламжлал, зан заншил, амьдралын үнэт зүйл, сэтгэлгээний онцлогийг гүнзгийрүүлэн судалж, үнэн бодитой дүгнэлт хийх явдал учир дутагдалтай явагдаж иржээ хэмээн үзэж байна. Чингис хааныг үнэлэх, түүний дэлхийн түүхэнд гүйцэтгэсэн үүргийг мушгин гуйвуулах явдал түгээмэл байв. Энд ерөнхийдөө хоёр хандлага голлож иржээ гэж үзэхээр байна.

Нэгдүгээрт, Чингис хаан бол үсэг бичиггүй, харанхуй бүдүүлэг байсан мэтээр бичсэн төдийгүй ерөөс Монголчууд үсэг бичиггүй байсан гэж үзэх хандлага. Ялангуяа энэ үед Монгол оронд ирж байсан жуулчид, элч төлөөлөгчид төдийгүй зарим судлаачид Чингис хаан үсэг бичиг мэддэггүй байсан гэж тэмдэглэсэн нь цөөнгүй. Оросын эрдэмтэн Б.Я.Владимирцов: *“Хааны өөрийн бие нь ерөөс уншлага, бичлэгийг сураагүй, мөн өөрийн эх хэл-монгол хэлнээсээ өөр ямарч улсын хэлийг мэдэхгүй”*¹ гэжээ.

Японы эрдэмтэн Хцүпүчи Такайши “Тэр бол /Чингис хааныг хэлжээ. Ж.З/ монгол хэлнээс өөр хэл мэддэггүй юм” гэж² онцлон тэмдэглэсэн байна. Эдгээр эрдэмтдийн бүтээлд хийсэн дүгнэлтийг авч үзэн өөрийн байр сууриа *“Чингис хааны бичиг үсгийн боловсролын тухайд”* гэсэн өгүүлэлдээ³ Чингис хаан бол бичгийн зохих боловсролтой, өөрийнхөө дэргэд олон орны эрдэмтэн мэргэдийг суулган дэлхий дахиныг засан тохинуулах бодлогоо боловсруулж, тэдний санал дүгнэлтийг сонсдог байсан төдийгүй Монголд цаас үйлдвэрлэл эрчимтэй хөгжиж Солонгос зэрэг оронд явуулдаг байсан жишээг дурдаж болно. Чингис хаан тухайн

* Ж. Заанхүү - Цагдаагийн академи, доктор, дэд профессор

үеийн чухал үйл явдлыг хөх дэвтэрт бичиж үлдээж байсны дээр өөрийн биеэр харж уншиж⁴ байсан гэх түүхийн баримтыг үндэс болгосон.

Дэлхийд анхны номыг хэвлэсэн гэх Германы И.Гутенбергээс 150 гаруй жилийн өмнө буюу 1298 онд Солонгост төмөр бар бүтээн ном хэвлэж, түүнд Монголын сурвалжит язгууртан Бэбуха хөрөнгө мөнгөөр ивээн тэтгэж байсныг солонгосын эрдэмтэд судлаачид тогтоосон байна⁵. Ийнхүү Эзэн Чингис хаанаасаа эхлэн монголчууд эрдэм номыг шүтэж байв.

Чингис хааныг үсэг бичгийн наад захын боловсролгүй гэх үзэл ийнхүү өөрийн үеийг өнгөрөөж байгаа бөгөөд тэрээр эрдэм мэдлэгийг дээдлэх, түүнийг бүх талаар дэлгэрүүлэн хөгжүүлэхэд ихээхэн анхаарч байжээ. Чингис хаан дэлхий дахины засан тохинуулах зорилт дэвшүүлж байсны хувьд олон улсын эрдэмтэн мэргэдийг энэ үйл хэрэгт дайчилж, тухайн үеийн дэлхий дахины улс төр, эдийн засаг, нийгмийн бодлогыг боловсруулахад үлэмж анхаарч, өөрийн хувь нэмэр оруулсан олон улсын төр, нийгмийн томоохон зүтгэлтэн байжээ гэж үзвэл зохино.

Хоёрдугаарт, Чингис хааныг алан хядагч, эвдэн бусниулагч, галдан шатаагч хэмээн үзэх хандлага. Чингис хааны байлдан дагуулал нь нэгэнт дайн байлдаан болохоор зохих хэмжээний эвдрэл сүйрэл, гамшгийг дагуулсан нь тодорхой боловч гадаад орнууд руу хийсэн аян дайны зорилго, үр дүнтэй нь холбон авч үзэх нь зүйтэй гэдгийг онцлон тэмдэглэж байна. Нөгөө талаар энэ үеийн баримт, сурвалж нь гол төлөв эзлэгдсэн орнуудын элч, төлөөлөгчид, түүхчдийн үзэл санаа болохоор Чингис хааны гадаадад хийсэн аян дайныг дан ганц хар бараан, сөрөг талаас нь авч үзэж, Чингис хааны харгис хэрцгий зан авир нь тэдний ялалт амжилтанд хүрэхийн баталгаа мэтээр авч үзэж байв. Энэ талаар: “Ер нь түүний /Чингисийн/ амьдрал нь энгийн хүмүүстэй жишин хэлэх аргагүй юм. Тэр цэргээ авч гарахдаа дэлхийн бөмбөрцөгийн өргөрөг уртрагыг хэв нэг алхан гарч замдаа тохиолдсон хот балгасыг газрын хөрснөөс арчиж, гол мөрний урсгалыг өөрчлөн ээрэм цөл, дүрвэгсэд үхэгсэдээр дүүрч цэцэглэн хөгжиж, нягт олон хүнтэй газар орон цөл тал болон хувирч тэнд ганцхан амьд амьтнаас чоно хэрээ хоёр үлдсэн юм” гэжээ⁶. Иймэрхүү үг өгүүлбэр гадаадын эрдэмтэд судлаачид, жуулчдын тэмдэглэлд цөөнгүй бий.

1920-иод оны үеэс манай орны гадаад улс төрийн тодорхой нөхцөл байдлаас үүдэн Чингис хааны үйл ажиллагаанд бодитой дүгнэлт өгөх явдал 1990 оныг хүртэл сүүлийн 70 шахам жилийн турш хаалттай байж, Чингис хааны талаарх Зөвлөлтийн эрдэмтдийн санал дүгнэлтийг

шууд хүлээн зөвшөөрөх хэмжээнд байв. Иймд Чингис хааны талаар тусгайлсан судалгаа хийх, уг үзлийг сөрөн зогсох бололцоо ч байсангүй.

Чингис хааныг Монголын нийгмийн өнцгөөр харвал

Чингис хааныг үнэлэх дээрх үзэл, хандлага дэлгэрэхэд олон гол хүчин зүйл нөлөөлсөн нь мэдээж. Монголчууд бол нэн бүдүүлэг, харанхуй хоцорогдсон гэсэн ойлголт гадаадын эрдэмтэд судлаачид, ялангуяа Өрнийн орнуудын хүрээнд ихээхэн дэлгэрч, тэдэнд нүүдэлчдийн соёлыг судлах, түүнийг хүлээн зөвшөөрөх соёл үнэндээ дутагдаж байв.

XIII зууны үеийн монголчуудын нийгмийн байгууллыг тун анхааралтай судлах явдал үндэсний төдийгүй олон улсын хүрээнд зайлшгүй чухал зүйл болоод байна. Учир нь монголчууд бол хүй нэгдлийн нийгмийн байгуулал овог аймгийн тогтолцоонд оршин байсан гэсэн үзэл ихээхэн байр суурь эзэлдэг бөгөөд суурьшмал улсын энэ ойлголтыг монголын нийгэмд, монголын хөрсөнд хялбарчлан буулгах боломжгүй нь судалгаагаар харагдаж байна. XIII зууны үеийн монголчуудын нүүдлийн амьдрал ХҮII зууны үед ч, ХХ зууны үед ч хэвээр хадгалагдаж байсан. XIII зууны үеийн монголчууд бол дэлхий дахиныг араасаа дагуулж чадах чадвартай ард түмэн байжээ. Монголчууд сэтгэхүйн цар хүрээний хувьд ч, эрхлэх аж ахуйн хувьд ч, тухайн үеийн цэрэг-үйлдвэрлэлийн технологийн хувьд ч, зам харилцаа дэд бүцийн ч, тухайн үеийн хамгийн хурдан, тэсвэр хатуужилтай тээврийн хэрэгсэл- монгол морийг эзэмшиж байсны тухайд ч бусад орноос ихээхэн давуу байсан бөгөөд энэ ч чанараараа дэлхий дахинд өөрсдийн ноёрхлоо тогтоосон байна.

Зарим судлаачид энэ “бүдүүлэг”, цөөн хүн амтай орон яаж “хөгжилтэй” бусад орныг нэг амьсгаагаар, нэг удаагийн цохилтоор дайран эзэлж байв гэж асуугаад яавч бүдүүлэг монголчууд ийм байх учиргүй гээд гайхашгаадаг.

Тэгвэл монголчууд бол оюуны гайхамшигтай ард түмэн бөгөөд үүний нууцыг өнөөдөр ч бүрэн тайлж судалгаа шинжилгээ хийгээгүй байна. Энд ганцхан баримтыг авч үзье. Нүүдэлчин монголчуудын хувьд өв уламжлалаа хадгалах, түүнийг хойч үеийхэндээ үлдээх гол арга нь аман яриа байдаг. Монголчууд суурин иргэдийн хэдэн арван ботиор хадгалан үлдээсэн тэр соёлын өвийг үндсэндээ аман яриагаар /Энэ нь нүүдэлчин ард түмний онцлог болон технологийн нууцыг хадгалан үлдээх өвөрмөц хэрэгцээнээс урган гарсан нь мэдээж хэрэг/ уламжлан үлдээнэ. Энэ чанараараа монголчууд бол юмыг цээжлэх, ой ухаандаа тогтоон хадгалах талаар гойд ард түмэн гэдгийг гадаадынхан төдий л анзаардаггүй.

Ганцхан жишээ авахад малчин айлын 10 орчим настай хүүхдэд гэхэд хэдэн зуун тэмдэгийг цээжлэх хэрэгцээ амьдралаас урган гардаг. Тухайлбал, нүүдэлчин малчин айлд бүх төрлийн мал байж сая тэдний хэрэгцээ хангагдана. Малчин нэг өрх хамгийн багаар 300 хоньтой гэж бодвол эдгээр хонины дор хаяж 70 хувь нь хургалж төллөнө гэвэл төдий хэмжээний тэмдэгт, 200 ямаатай гэвэл түүний 70 хувь нь төллөнө гэж бодоход тэр хэмжээний тэмдэгт, адуу, тэмээ, үхэр нийлээд 100 бод байна гэж үзвэл түүний төлийг тавин хувь гэж бодоход нэг малчин айл өрхийн хүүхэд наад зах нь 1000 шахам тэмдэгт /300 хонь+210 хурга+200 ямаа+140 ишиг+100 бод+70 бодын төл = 950/-ийг тогтоон цээжилнэ гэсэн үг. Мөн айл саахалтынхаа малыг малчин бүр зүслэн тогтоох хэрэг гарна.

Түүний мэдвэл зохих тэмдэгт үүгээр хязгаарлагдахгүй. Тухайн өрх эргэн тойрондоо 50 километрт мал ахуйгаа хариулж бэлчээдэг гэж үзвэл энд байгаа уул, ус, дов толгод, бууц, жалга бүрийн нэр, энд ургасан өвс ургамал бүрийн нэрийг мэдэх хэрэгцээ шаардлага гарна. Түүнчлэн өвөг дээдсийн нэр, уламжлагдаж ирсэн ардын аман зохиол, дуу хуур, үлгэр тууль зэргийг мөн л аман яриагаар өвлөн авах шаардлага гарна. Ийнхүү монголчууд байгалиасаа, мал аж ахуй эрхлэхтэй холбогдсон хөдөлмөр, үйл ажиллагаа, монгол ахуйгаасаа шаардлагатай бүхий л мэдээлэл, оюуныхаа шавхагдашгүй нөөцийг бий болгодог байна.

Харин суурьшмал иргэдийн хаяа дэрлэн нэг дор байрласан малчдын үйл ажиллагаанаас тэс өөр гэдгийг тэмдэглэн хэлэх нь зүйтэй. Энэ бүхнийг бичиг цаасан дээр бичээд байх боломж, шаардлага байхгүй бөгөөд зөвхөн оюун тархиндаа л үлдээн буулгана. Жирийн монгол малчин бол бичиг үсэг мэддэггүй байлаа ч байгалийн шинжлэлийн том мэргэжилтэн, газар зүйч, одон оронч, мал зүйч, малын эмч, мал аж ахуйн бүх төрлийн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэгч, зохион бүтээгч болдог. Монголчуудын мэдлэг, оюун ухаан нь ийнхүү байгалиасаа тэжээгдэж байдаг болохоор ширгэшгүй ундаргатай.

Хэрэв Чингис хаан дэлхийн түүхэнд ул мөрөө гүнзгий үлдээсэн суу билэгтэн, мянганы содон хүн юм бол түүнийг ургуулагч хөрс нь нүүдэлчдийн өргөн хүрээтэй, баялаг агуулгатай соёл байх бөгөөд нүүдэлчид нь Европынхны хэлдэгээр “варварууд” биш, тухайн үедээ дэлхий дахины бодлогыг тодорхойлон чиглүүлэгчид байв. Монгол хүний оюуны чадварын судалгааг цаашид гүнзгийрүүлэх шаардлага зүй ёсоор хүлээгдэж байна.

Монголын эзэнт гүрний үед монголд ирж байсан элч, төлөөлөгчдийн хувьд монголчуудын хэл, ёс заншил, уламжлал, ахуй

амьдралыг гүйцэд ухаарах боломж тухайн үед хязгаарлагдмал байсантай холбоотой монголчуудыг “зүхэн гутаах”-д чиглэсэн олон тооны тэмдэглэл, тайлан өнөөг хүртэл хадгалагдан үлдсэн байна. Монголын байлдан дагууллын эцсийн зорилго нь дэлхий дахинд энх тайван, аюулгүй байдал тогтооход чиглэгдсэн дэлхий дахиныг засан тохинуулах үйл ажиллагаа байсан гэдгийг тухайн үед Монгол улстай хөрш зэргэлдээ оршин байсан улсуудын хаад төдийгүй ард түмэн ойлгоогүй, ойлгох хүсэл, боломж ч байсангүй.

Ийнхүү нүүдэлчин Монголчуудын олон талт амьдрал, тэдний гүн ухааны үзлийг нарийвчлан судлан монгол ахуй, ёс заншлын нууцад нэвтэрч, улмаар Чингис хааны үнэн түүхийг дэлгэн тавих нь зүйтэй гэсэн санааг дэвшүүлж байна.

Чингис хааны тухайн үедээ явуулж байсан гэр бүл, улс үндэстэн, дэлхий дахины шинж чанартай улс төр, эдийн засаг, цэрэг, иргэний шинж чанартай бодлогыг бүхэлд нь *засан тохинуулах үйл ажиллагаа* хэмээн томъёолж байна. Энэ ч утгаараа Чингис хаан эхлээд өрх гэрийн хүрээнд засан тохинуулах, дараа нь улс үндэстний хүрээнд засан тохинуулах, эцэст нь дэлхий дахины хэмжээнд засан тохинуулах бодлогоо тодорхойлон түүнийг хэрэгжүүлэхийн төлөө өөрийн бүхий л ухамсарт амьдралаа зориулсан суу билэгтэн байв.

Дэлхий дахиныг засан тохинуулах үзэл санаа Чингис хаанд шууд бүрэлдэн бий болоход XIII зууны Монголын төдийгүй хөрш зэргэлдээ орнуудын нийгмийн дотоод байдал, монгол туургатан төдийгүй дэлхийн хүн амыг амар амгалан байлгах гэсэн тухайн үеийн олон улсын хэрэгцээ шаардлагаас урган гарчээ гэж үзэхээр байна.

Чингис хааны засан тохинуулах үзэл санаа нь Монголчууд төдийгүй тухайн үеийн ард түмний олон үеийнхний хүсэл тэмүүлэл байсан бөгөөд хэн нэгэн аугаа хүнийг гаргаж тавих түүхийн захиалгаар хийгджээ хэмээн дүгнэж байна.

Энэхүү захиалгыг Монголчууд биелүүлж чадсан бөгөөд энэ нь *Монголын нүүдлийн тогтолцоот нийгэм, түүний* онцлог-суурин иргэдийг бодоход илүүчлөөтөй аж төрж, тодорхой хил зааг тогтоохгүйгээр өөрийн дураар нүүдэллэн амьдрах хүсэл тэмүүлэл, бололцоо, харьцангуй хэнээс ч “хараат бус” шинж чанар, бүх зүйл алган дээр байгаа юм шиг “*нээлтэй*” байдал, энэ утгаараа нийгмийн аливаа асуудлыг ил тод, шударгаар шийдвэрлэх хүсэл эрмэлзэл зэрэг нь тухайн үеийн улс орнуудын дотоод, гадаад нөхцөл байдлыг илүү бодитой мэдэрч түүнийг засан сайжруулах арга зам монголчуудад илүү ойр дөхөм байв.

Чингис хаан Монголын нийгмийн энэ хэрэгцээ шаардлагыг зөвөөр тусган гарч ирсэний дээр нүүдэлчдийн нийгмийн хамгийн шилдэг сэтгэлгээний илэрхийлэл болон түүхийн тавцанд гарч иржээ.

Хэрэв Чингис хаанд аугаа их билэг авьяас байгаа бол энэ нь тухайн үеийн Монголын нийгмийн өөрийнх нь дотоод мөн чанар, агуулгатай салшгүй холбоотой хэмээн дүгнэж байна.

Монголын эзэнт гүрний үед цэргийн зэвсэглэлийн технологид гарсан нэг томоохон өөрчлөлт бөгөөд дэлхий дахинд галт зэвсгийг дэлгэрүүлэн нэвтрүүлэхэд Чингис хаан болон Монголчууд чухал хувь нэмэр оруулжээ. Үүнийг Английн эрдэмтэн Ж.Ж.Саундерс “Монголын байлдан дагууллын түүх” хэмээх бүтээлдээ Монголчууд хаан Белагийн командалсан Унгарын армийг устгасан Сажогийн тулалдаанд 1241 оны 4 дүгээр сарын 11-нд дарь буюу гунан бууг / латин үсгээр “gun” гэж⁷ бичдэгээс монголын “*гунан*” гэсэн үг гарсан байж болох юм. орч./ хэрэглэж байсныг дурдсан байна. Үүнээс үзэхэд гунан гэдэг нь цэвэр монгол үг Европт нэвтэрч өөрийн утга агуулгаараа үлдсэн болох нь харагдаж байна. Монгол хэлэн дэх гунан гэдэг үг нь гурван настай үхэр, энэ үхэртэй харьцуулж болохуйц том хэмжээний буу хийсэн гэсэн утга санаа байгаагийн хамт, гунан үхрээр чирж явах гэсэн санаа илэрхий байна.

Энэ нь латины “gun” гэсэн үг монголд орж ирсэн биш, харин эсрэгээр монголын *гунан* гэсэн үг латин хэлэнд тэр чигээрээ орсон нь тодорхой байна. Эрдэмтэн Ж.Базарсүрэн⁸, Дамдинсүрэн⁹ нар Чингис хааны цэргийн зэр зэвсэг бүтээлдээ монголчууд дарьт зэвсгийг хэрэглэх болсон талаар тодорхой өгүүлсэн байдаг.

Чингис хаан болон түүнийг залгамжлагчид Хятад орны хоёр эзэнт гүрнийг байлдан дагуулаад луужин, дарь, цаас, торго мэтийг хийх арга технологийн¹⁰ нууцын эзэд болж, тэдгээрийг Энэтхэг, Дундад Ази, Ойрхи Дорнод, Европ дахь Монголын эзэмшил улс орнуудад тараан түгээсэн байна.

Ийнхүү Чингис хаан XIII зууны дэлхий дахиныг нэг жолоонд оруулж дэлхий дахиныг засан тохинуулсан нь түүний үлдээсэн агуу их өв сан бөгөөд тэр өнөөгийн даяарчлалыг эхлүүлсэн байна. Өнөөдөр ч дэлхий дахиныг засан тохинуулах, нэгдмэл дэлхий бий болгох үзэл санааг дэлгэрүүлэхэд Чингис хааны үлдээсэн өв санг гүнзгийрүүлэн судлах явдал чухал байна

ИШЛЭЛ, ЗҮҮЛТ

1. Б.Я.Владимирцов *Чингис-хан*. Улан-Удэ.1995. 52 дахь тал
2. Хцүлүчи Такайши, Отаки Мацүво. *Чингис хаан, Хубилай хаан*. Өвөр Монголын сурган хүмүүжлийн хэвлэлийн хороо.1987. 245 дахь тал
3. Ж.Заанхүү “*Чингис хааны бичиг үсгийн боловсролын тухайд*” Чингис хааны 840 жилийн ойд зориулан МУИС дээр болсон олон улсын эрдэм шинжилгээний хуралд тавьсан илтгэл. *Үлэмжийн их Чингис хаан* номд хэвлэгдсэн өгүүллийг үз.
4. Бумбын шавь Ли Хи Чаний зохиосон “*Чань Чунь бумбын баруунш зорчсон тэмдэглэл*” гэдэг номдоо нарийн тодорхой тэмдэглэн үлдээжээ. Энэхүү номыг бичихдээ Чингис хааны “Гадагш задруулж үл болмой” гэсэн зарлиг, тухайн үед цэрэг дайны нууц материал гэдэг утгаар нь оруулаагүй байна. Харин түүнийг хожим Елюй Чуцай эмхэтгэн гаргасныг “*Бумбын суртлыг дэлгэрүүлсэн баярын хуримын тэмдэглэл*” гэж нэрлэдэг. Энэ ховор материалыг Жечияны ардын хэвлэлийн хорооноос 1990 онд хэвлэн тараасан “Бумбын суртахууны ганжуур”-т оруулсан байна. Үүнийг нөхөр Хүчихэн “Чань чунь бумбын баруунш зорчсон тэмдэглэл” гэдэг номыг эмхэтгэх үедээ олоод монголчилж тус номын дагалдуулалд хавсаргасан. 240 дэх тал/
5. Б.Цогтбаатар *Монголд цаас үйлдвэрлэж байв*. Манай Монгол сэтгүүд. 1999.№2. 35-37 дахь тал
6. Английн эрдэмтэн Ральф Фохс *Чингис хаан*. Лондон. 1936. Ш.Нацагдорж *Чингис хааны цадиг*. УБ. 1991. 297 дахь талыг үз.
7. Ж.Ж.Саундерс *Монголын байлдан дагууллын түүх*. Англи хэлнээс орчуулсан Ж. Гэндэндарам УБ. 1992. 226 дахь тал/
8. ...дарь хятадад бий болж, цэрэг дайнд анхлан хэрэглэсэн гэдэг нь үнэн боловч, түүнийг хэрэглэх аргыг улам төгөлдөржүүлэн цэрэг, дайнд өргөн ашиглаж, дэлхий дахинд түгээн тараахад монголчууд гол үүрэг гүйцэтгэсэн байна гээд: “Ямар боловч Хятаны үеийн галт зэвсгийн уламжлал ор тас мартагдах үндэсгүй бөгөөд харин ч төгөлдөржин боловсорч байснаас монгол цэрэг XIII зууны 20-иод оноос дарьт буюу галт зэвсгийг өргөн дэлгэр хэрэглэж эхэлжээ. Ж.Базарсүрэн *Чингис хааны цэргийн зэр зэвсэг*. УБ. 2000. 155 дахь тал үз.
9. А.Дамдинсүрэн: “XIII зууны эхэн үеийн Монгол цэргийн зэвсэглэлд галт их буу, арван таван гуурст шувтлагч буу гэх мэт сүр хүчин төгөлдөр буунуудыг хэрэглэж байсан” гэжээ. А.Дамдинсүрэн *Монголын зэвсгийн товч түүх* УБ. 1990. 112 дахь тал үз.
10. Ялбак Халбай Суу билэг төгс Богд эзэн *Чингис*. Түүхэн эсээ. Орчуулсан Ч.Баатар. Хянан тохиолдуулсан Ч.Ганболд.УБ.2004.195-196 дахь тал үз.